



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 545

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн, төлбөр төлөхөөс татгалзсан зарим хуулийн этгээдээс буцааж авсан хөрөнгийг төрийн өмчит зарим хэрэгцээтэй байгууллагад хуваарилан эзэмшүүлэх шаардлагын үүднээс ТОГТООХ нь:

1. Буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэгдсэн 17,350,000.00 (арван долоон сая гурван зуун тавин мянган) төгрөгийн үнэ бүхий тавилгыг хавсралтад заасны дагуу үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг төрийн өмчит холбогдох хуулийн этгээдэд зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Үндсэн хөрөнгө бүртгэх, акталж устгах зөвшөөрөл олгох тухай” 318 дугаар тогтоолын 3 дахь заалт болон 5 дугаар хавсралт дахь “...102,237,000.00 (нэг зуун хоёр сая хоёр зуун гучин долоон мянган) төгрөгийн...” гэснийг “...84,887,000.00 (наян дөрвөн сая найман зуун наян долоон мянган) төгрөгийн...” гэж тус тус өөрчилсүгэй.

3. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ё.Нямжавт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

3.1. Хөрөнгийг худалдан борлуулснаас орох орлогыг Төрийн сан дахь улсын төсвийн өмч хувьчлалын орлогын 100900000721 тоот дансанд төвлөрүүлэх;

3.2. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002445

Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгах
ТАВИЛГА, ЭД ХОГШЛЫН ЖАГСАЛТ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 1-ны өдрийн
545 дугаар тогтоолын 1 дугаар хавсралт

Д/д	Хуулийн этгээдийн нэр	д/д	Хөрөнгийн нэр	Тоо		Бүгд үнэ (төгрөг)
				хэмжээ	Нэгжийн үнэ (төгрөг)	
1	Батлан хамгаалах яам	1	3 хүний матрас	17	75,000	1,275,000
		2	2 хүний матрас	5	90,000	450,000
		3	2 хүний матрас	3	75,000	225,000
		4	1 хүний матрас	19	50,000	950,000
2	Хил хамгаалах ерөнхий газар	5	2 хүний матрас	2	75,000	150,000
		6	2 хүний матрас	47	75,000	3,525,000
		7	1 хүний матрас	15	50,000	750,000
		8	2 хүний матрас	15	90,000	1,350,000
		9	2 хүний матрас /2000х2200/	53	75,000	3,975,000
		10	Кресло	2	185,000	370,000
		11	Гартай сандал / нам түшлэгтэй лонж /	2	75,000	150,000
4	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК	12	Хагас буйдан / цэнхэр буйдан /	1	95,000	95,000
5	"Дорноговь АЗЗА" ТӨХК	13	Гартай сандал / нам түшлэгтэй лонж /	2	75,000	150,000
		14	Хөлийн тавиур	2	115,000	230,000
6	"Өвөрхангай АЗЗА" ТӨХК	15	Гартай сандал / нам түшлэгтэй лонж /	2	75,000	150,000
		16	4 хүний матрас	18	75,000	1,350,000
7	"Спорт бэлтгэлийн төв" ТӨҮГ	17	2 хүний матрас	3	90,000	270,000
		18	2 хүний матрас	3	75,000	225,000
		19	1 хүний матрас	1	50,000	50,000
		20	Ажлын сандал	5	150,000	750,000
8	"Талын зам" ТӨХК	21	Хөлийн тавиур	2	115,000	230,000
		22	Хагас буйдан /цэнхэр буйдан/	2	95,000	190,000
		23	Гартай сандал /нам түшлэгтэй лонж/	2	75,000	150,000
9	"Төв АЗЗА" ТӨХК	24	Гартай сандал /нам түшлэгтэй лонж/	2	75,000	150,000

Д/д	Хуулийн этгээдийн нэр	д/д	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төгрөг)	Бүгд үнэ (төгрөг)
10	"Увс АЗЗА" ТӨХК	25	Хагас буйдан /цэнхэр буйдан/	1	95,000	95,000
11	"Ховд АЗЗА" ТӨХК	26	Хагас буйдан /цэнхэр буйдан/	1	95,000	95,000
	Нийт дүн					17,350,000
						(арван долоон сая гурван зуун тавин мянга)